



## НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ЧУУЛГЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар Б/10

Улаанбаатар хот


Г

Т

Албан хаагчдад ур чадварын  
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус чуулгын албан хаагчдын 2020 оны нэгдүгээр улирлын ажлыг дүгнэн ур чадварын нэмэгдэл олгох жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Ур чадварын нэмэгдэл цалинг 2020 оны 03 дугаар сарын 20-ны дотор бодож олгохыг нягтлан бодогч /С.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер /Л.Одгэрэл/-д үүрэг болгосугай.





## НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ЧУУЛГЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 5/11

Улаанбаатар хот

Г

Г

Албан хаагчдад  
урамшуулалт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Нийслэлийн засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/342 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээг нэвтрүүлэх, заавар зөвлөмж хүргэх болон дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Короновирус (COVID-19) гарч, халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт болзошгүй эрсдлээс сэргийлэх, ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг тогтмолжуулах, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих ажиллагаанд идэвхитэй, хариуцлагатай оролцсон албан хаагчдыг хавсралт ёсоор баталж, урамшуулсугай.
2. Тус тушаалын 1 дүгээр заалтад тусгасан үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон албан хаагчдын урамшуулалд олгох мөнгөн хөрөнгийг байгууллагын 1 дүгээр улирлын батлагдсан цалингийн санд багтаан, 2020 оны 03 дугаар сарын 20-ны дотор бодож олгохыг нягтлан бодогч /С.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер /Л.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Р.МОНХСАЙХАН

